

**Сургуулиас хөөх тухай мэдэгдэл - 17 ба түүнээс дээш
насны сурагчдын хичээл, сурлагын идэвхгүй байдал**

Утсан орчуулгын үйлчилгээг ашиглан сургуультай холбогдох нь

Сурагчийн нэр
Name of student

Эрхэм хүндэт эцэг эх/асран хамгаалагч танаа

Хавсаргасан захидалд NSW мужийн Боловсролын Яамны Сурагчийн Зан Авирын Тухай Бодлого, мөн Сургуулиас Түр Чөлөөлөх болон Хөөх Журмын дагуу таны хүүхдэд өгсөн “Сургуулиас хөөх тухай мэдэгдэл – хичээлд идэвхгүй байдал”-н тухай дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан болно.

Таны хүүхэд захирлын зөвшөөрөлгүйгээр энэ сургуульд буцаж суралцах боломжгүй. Хэрэв та хүүхэддээ үргэлжлүүлэн боловсрол эзэмшүүлэхийг хүсч байвал тохирох боловсролын байгууллага олж өгөх нь таны үүрэг юм. Бусад боломжит хувилбаруудын талаар зөвлөгөө авахыг хүсвэл сургуультай холбоо барьж болно.

Хүүхэд тань сургуулиас хөөгдсөн тохиолдолд таны мэдэх шаардлагатай мэдээллийг бид энд хавсаргав.

Хэрэв танд хавсаргасан захидлыг ойлгоход хүндрэлтэй байвал сургуультай холбоо барина уу. Бид танд тайлбарлаж өгөх болно. Хэрвээ та хүүхдийнхээ сургуультай холбогдох хүсэлтэй бөгөөд танд англи хэлний тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн ярихыг хүссэн хэлээ мэдэгдэн, сургуультай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Уг үйлчилгээ нь үнэ төлбөргүй.

Захирлын нэр
Name of Principal

Захирлын утасны дугаар
Principal's phone number